



СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас: 70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Ахлах аудитор:
К.Риза
Утас: 94156768
Цахим хаяг:

Хаяг: Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.audit.mn

2018 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Сум дундын Ойн ангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /БӨА-2018/ 79/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Сум дундын Ойн ангийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Сум дундын Ойн ангийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 02-ноос 2 дугаар сарын 07-ны хооронд хийхээр төлөвлөн, ахлах аудитор К.Риза хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Сум дундын Ойн анги нь 2017 оны санхүүгийн тайланг хуулинд заасан хугацаанд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 25-наас 2 дугаар сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 28-нд Сум дундын Ойн ангийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Сум дундын Ойн ангийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, **Ойн тухай** хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Ойн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-д “ Сум дундын болон сум, дүүргийн ойн анги нь ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах, бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгох, сум, дүүргийнхээ ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх хөтөлбөр болон менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх; ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, ойн баялгийг ашигласны төлбөр, хураамжийг ногдуулж, тэдгээрийн гүйцэтгэлийг хангах; аймаг, сумын түвшинд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж буй бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, мэдээллийн санг эрхлэх; иргэдэд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, ойг түймэр, хөнөөлт шавж, өвчин зэрэг байгалийн гэнэтийн аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэдгээртэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэж тус байгууллагын эрх үүрэг, зорилтыг тодорхой заасан байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Сум дундын Ойн ангийн Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Сум дундын Ойн ангийн 2017 оны төсвийг орон нутгийн төсвөөс аймгийн төрийн сангаар дамжуулан олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сум дундын Ойн ангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Сум дундын Ойн ангийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг

тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 11-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.

Сум дундын Ойн ангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Сум дундын Ойн анги нь санхүүгийн программгүй ба санхүүгийн үйл ажиллагааг Ексел программаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Сум дундын Ойн ангийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Орон нутгийн төсвөөс аймгийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэнээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Сум дундын Ойн ангийн төсөв захирагч нь 2017 онд үйл ажиллагааны төсөвт 101,4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ. Гүйцэтгэлээр 101,4 сая төгрөгийн санхүүжилт авч батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Үүнээс гадна тус газарт 2017 онд чиг үүргийн дагуу Ногоон хэрэм төсөл хөтөлбөр, ойн цэвэрлэгээ, арчилгаанд зориулан Ойн судалгаа хөгжлийн төв болон аймгийн БОАЖГазраас нийтдээ 17,7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон байна.

Гүйцэтгэлээр “Ногоон хэрэм” төслийн хүрээнд 12,9 сая төгрөгийн, Ойн арчилгаа цэвэрлэгээнд 4,8 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэн ажлын гүйцэтгэлийг Ойн судалгаа хөгжлийн төвд хүргүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу shilendans.gov.mn вэб сайтанд байгууллагын 2017 оны батлагсдан төсвийн мэдээллийг оруулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Аудитаар санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхээр зөрчил илрээгүй болно.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Сум дундын Ойн ангийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт орлого, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин, түрээсийн төлбөр, хөтөлбөр арга хэмжээний зардлууд зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант оны онцлог гүйлгээний талаар тодруулбал:

Тайлант онд онцлог гүйлгээ гараагүй байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитаар санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц материаллаг алдаа зөрчил илрээгүй. Материаллаг бус дараах асуудал байна.Үүнд:

1.Сум дундын Ойн ангийн 2017 оны төсөвт 7 орон тоогоор ажиллахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 8 орон тоогоор үйл ажиллагаа явуулж, орон тоог 1-ээр хэтрүүлсэн байна. Энэ нь Өлгий сумын мэдэлд байгаа Толбо сумын зам дагуу байгаа ойжуулалтын ажлыг тус Ойн ангийн мэдэлд шилжүүлсэнтэй холбоотойгоор 1 хүнийг шилжүүлэн ажиллуулж байгаатай холбоотой.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Сум дундын Ойн ангийн санхүүгийн тайланд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Сум дундын Ойн анги нь батлагдсан орон тооноос 1 орон тоог илүү ажиллуулж байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн аудитаар тус газрын орон тооны асуудлыг авч үзэх шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сум дундын Ойн ангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, хавсралт хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.ХУАНГАН
ОГНОО: 2018.02.25
Х.ЖЕНИСБЕК
ОГНОО: 2018.02.25

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

К.РИЗА

ОГНОО:2018.02.25